

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг журам 2023 он



**БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЖУРАМ**

Хувилбарын дугаар:1
Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-10-25
Баримт бичгийн дугаар:01

Баримт бичгийг хариуцах нэгж	Нийт тасаг, нэгжүүд		
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл	Дотоод	Баримт бичгийн түвшин	3
	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан.	Ц.Лувсандамдин Б.Эрдэнэзул	ЭМТҮЧАБ Албаны дарга Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер	
Санал өгсөн.	Д.Баянмөнх	Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	
Хянаж баталсан.	Г.Дашжанцан	БООТөвийн захирал	



Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлтийг батласан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсонг товч тайлбарлана)
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			
10			

АГУУЛГА	
1. ЗОРИЛГО.....	4
2. ХАМРАХ ХҮРЭЭ.....	4
3. НЭР ТОМЪЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД.....	4
3.1 Нэр томъёо.....	4
3.2 Товчилсон үг.....	4
3.3 Иш татсан баримт бичгүүд.....	4
4. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АЖИЛЛУУЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	5-7
5. ШИНЭЭР АЖИЛД ОРЖ БУЙ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД ӨГӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	8-10
6. ҮЙЛЧЛЭГЧИЙН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА.....	11-13
7. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН АВТОМАШИН ЖОЛООЧ, АЛСЫН БОЛОН ОЙРЫН ДУУДЛАГАД ЯВАХ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН НАРТ ӨГӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	14-18
8. ХАРУУЛЫН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА.....	19-20
9. БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЖУРАМ	21-23
10.АЛБАН ТАСАЛГААНД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА.....	24-28
11.ХАРИУЦЛАГА.....	

НЭГ. ЗОРИЛГО:

Энэхүү журмын зорилго нь Бүсийн Оношилгоо эмчилгээний төвийн /цаашид БОЭТ-ийн гэх/ нийт ажилтнуудын эрүүл аюулгүй орчинд ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх, ажлын байрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадлыг хэвшүүлэхэд оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ:

БОЭТ-ийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн дагаж мөрдөнө.

ГУРАВ. НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД

Нэр томъёо

- БОЭТ- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- ЭЭДЗ-Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
- ЭТҮЧАБА- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба
- ХАБЭА-хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- АХ-ажлын хувцас
- ЭХ-эдэлгээний хугацаа
- ХХХ-хамтын хамгаалах хэрэгсэл
- ХНБХХ-хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл
- САЗ-сувилахуйн арга зүйч

Иш татсан баримт бичиг

- Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5095:2017 стандарт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023
- Эрүүл мэндийн байгууллагын чанар аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл төлөвлөгөө батлах ЭМС-ын 2017 оны 514 тоот тушаал
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах зарим арга хэмжээний тухай ЭМС-ын 566 тоот тушаал

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АЖИЛЛУУЛАХ ҮЕИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Эмнэлгийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламжийн үйлчилгээг холбогдох дүрэм, журмын дагуу мэргэжлийн инженер, техникийн ажилтан хийж гүйцэтгэнэ.
2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилтан нь тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны мэргэжлийн удирдлагаар хангаж, сургалтыг зохион байгуулна.
3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын үзлэг, шалгалт, төлөвлөгөөт засвар, үйлчилгээ, тохиргоог үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу хийж, ашиглалтын аюулгүй ажиллагааг хангаж, техник ашиглалтын паспортод тэмдэглэл хөтөлнө.
4. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нарийн мэргэжлийн засвар үйлчилгээ, угсралт суурилуулалт шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.
5. Өөрийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, цахим системд олон улсын нэршил, эрсдэлийн ангиллын дагуу бүртгэн, өөрчлөлтийг тухай бүр хийж, мэдээллийн санг бүрдүүлнэ.
6. Шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалтыг мэргэжлийн байгууллагаар холбогдох хууль, журмын дагуу хийлгэсэн байна. Шалгалт тохируулга, шалгалт баталгаажилт хийлгээгүй, түүнд тэнцээгүй эсхүл гэмтэлтэй тоног төхөөрөмжийг оношилгоо, эмчилгээнд ашиглахыг хориглоно.
7. Тоног төхөөрөмжийг актлах, урсгал, төлөвлөгөөт засварт оруулах, шинээр шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгаа захиалгыг гаргаж мөрдөж ажиллана.
8. Механик, электрон болон бохирдсон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тус тусын өрөөтэй байх ба шаардлагатай тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, яхналт тохируулгын багаж хэрэгслээр хангагдсан байна.
9. Шаардлагатай тасаг нэгжид хүчилтөрөгч, шахсан агаар, вакуум зэрэг хийн хангамжийн системтэй байх ба холбогдох стандарт, заавар, журмын дагуу аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана.

10. Эмнэлгийн, эмнэлгийн бус тоног төхөөрөмж нь газардуулгын системд холбогдсон байх, мэргэжлийн байгууллагаар хяналт баталгаажуулалт хийлгэсэн байна.
11. Эмнэлгийн цахилгаан хангамж нь тогтвортой, хэлбэлзэлгүй байх ба цахилгааны гадны болон дотоодын нөөц эх үүсгүүртэй байна.
12. Мэс засал, яаралтай тусламж, лаборатори зэрэг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж нь хүчдэл тогтворжуулан барих төхөөрөмжтэй байна.
13. Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдал, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангасан, төрөлжсөн цахилгаан шаттай байна.
14. Эмнэлэг нь ердийн болон тусгай зориулалтын агааржуулалтын системтэй байна. Агааржуулалтын системд сард нэг удаа үзлэг шалгалт хийж аюулгүй ажиллагааг ханган ажиллана.
15. Шаардлагатай тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс гаргасан шаардлагын дагуу цэвэршүүлсэн усан хангамжийн системд холбосон байна.
16. Гар болон цахилгаан тоног төхөөрөмжүүд дээр ажиллахдаа тоног төхөөрөмжийг ажилуулахын өмнө цахилгаан тэжээлд холбогдсон эсэх, цахилгааны утас шалбархай, салсан, хөндийрсэн зүйл байгаа эсэхэд үзлэг шалгалт хийх, хэрэв ямар нэгэн зөрчил байвал засварлаж зөрчлийг арилгасны дараа ажил үүргээ гүйцэтгэх,
17. Цахилгаан тоног төхөөрөмж гэмтэлтэй байж болзошгүй тохиолдолд мэргэжлийн цахилгаанчин, эсвэл тоног төхөөрөмж хариусан инженерт мэдэгдэж үзлэг хийлгэж шалгасны дараа ажиллуулна.
18. Ус чийг буюу нойтон шалан дээр цахилгаан багаж тоног төхөөрөмжөөр ажиллах, шалан дээр тавих зэргээс зайлс хийх
19. Цахилгаан хөрөө, точиль, өрөм зэрэг гар болон цахилгаан багаж тоног төхөөрөмжтэй ажил үүрэг гүйцэтгэхдээ тухайн багаж тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалт хэвийн байгаа эсэх, зориулалтын ир, шөвөг хийсэн эсэхэд үзлэг шалгалт хийсний дараа ашиглах,
20. Шатдаг хийн түлшний тоног төхөөрөмжийг хариуцагчаас өгсөн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.
21. Агааржуулалтын систем ажиллагаагүй үед хийн тоног төхөөрөмжийг ашиглахыг хатуу хориглоно.
22. Цахилгаан тоног төхөөрөмж ажиллаж байх үед ажлын байранд ил гал гаргах, тамхи татахыг хатуу хориглоно.

23. Цахилгаан тоног төхөөрөмж ажиллаж байхад түүний дэргэд гадны хүн, бага насны хүүхэд, аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй хүн байхыг хориглоно.
24. Ажил үүрэг гүйцэтгэж байхдаа багажийг буруу барих, төмөр, мод зэргээр цохих, зориулалтын бусаар ашиглахыг хатуу хориглоно.
25. Ээлж хүлээлцэхдээ эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг давхар хүлээлцэх ба заавал бүртгэл хөтлөнө. Тоног төхөөрөмж хариуцсан инженерийг байлцуулан асаах унтраах үйлдлийг хийж хэвших
26. Аливаа тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг эмнэлгийн тоног төхөөрөмж хариуцсан инженерүүдэд мэдэгдэж засуулах бөгөөд тухайн тоног төхөөрөмжийн “техник ашиглалтын паспорт”-д засвар үйлчилгээний талаар тэмдэглэл хөтлүүлэн гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
27. Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмжийг ажиллуулахын өмнө ажлын байрын үзлэгийг хийсний дараа ажиллуулна.
28. Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмжийг ажиллуулахдаа зааврын дагуу асааж унтраах үйлдлийг хийнэ.
29. Аливаа тоног төхөөрөмжийн ажиллагаа доголдсон эвдэрсэн тохиолдолд инженерт мэдэгдэж, нэн даруй холбогдох албан тушаалтанд мэдэгдэж зохих арга хэмжээг авхуулна.
30. Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмж багаж хэрэгслийн цэвэрлэгээг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 сарын 29 ны өдрийн А/537 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах зааврын дагуу хийнэ.

ШИНЭЭР АЖИЛД ОРЖ БАЙГАА ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД
ӨГӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Шинээр ажилд орж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 2 цагийн сургалтанд хамрагдаж, ажлын байран дахь урьдчилсан зааварчилгааг авсны дараа ажил үүрэг гүйцэтгэнэ.
2. Хуваарилагдсан тасаг, албаны САЗ-ээс тухайн ажлын байран дахь өдөр тутмын давтан зааварчилгааг ажил эхлэхийн өмнө авч гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
3. Ажлын хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зүй зохистой бүрэн гүйцэт зөв өмсөж ажиллах
4. Эмнэлгийн орчинд мөрдөгдөх хууль, дүрэм, журам, зааварчилгаа, стандартын хэрэгжилтийг ханган ажиллах
5. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу гар угаах, халдваргүйжүүлэх зааврын хэрэгжилтийг ханган ажиллах, бохирдсон тохиолдол бүрт гарыг 1 минут угаах, үйлчлүүлэгчтэй харьцахын өмнө гараа угаасан байх
6. Үйлчлүүлэгчтэй зөв ёс зүйтэй харилцах, албадын дарга болон холбогдох албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь гүйцэтгэн ажиллах
7. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй бүх үйлчлүүлэгчид таних бугуйвч зүүлгэнэ.
 - Шар өнгийн бугуйвч- үйлчлүүлэгч унах эрсдэлийг эмчлэгч эмч, тасгийн эрхлэгч үнэлж эрсдэлийг үнэлэн шар бугуйвч зүүлгэнэ.
 - Улаан өнгийн бугуйвч-сувилагч эмчлүүлэгчийг хүлээн авч зүүн бугуйд бугуйвчийг зүүж өгөх ба эмчээс тодруулан харшил илэрсэн тохиолдолд улаан өнгийн бугуйвчийг зүүлгэнэ.
 - Цагаан өнгийн бугуйвч-шинээр төрсөн нярай болон хэвтэн эмчлүүлэгчдэд цагаан өнгийн бугуйвч зүүлгэнэ.
 - Цэнхэр өнгийн бугуйвч-эмчлүүлэгчийн биеийн байдал хүндэрсэн үед цэнхэр өнгийн бугуйвч зүүлгэнэ.
 - Ногоон өнгийн бугуйвч- эмчлүүлэгч мэс засал буюу хагалгаанд орсны дараа ногоон өнгийн бугуйвч зүүлгэнэ.
8. Үйлчлүүлэгчтэй үр дүнтэй харилцаа тогтооно. Угтан мэндчлэх, инээмсэглэх, үйлчлүүлэгчиг суулган дотно уу амьсгал бүрдүүлэх, өвчний талаар таниулах

материал бусад зүйлийг ашиглан энгийн үгээр тайлбарлана. Гэрээр хийх асарга эмчилгээг зааж ойлгосон эсэхийг шалгах, өөрөөр нь давтан хэлүүлэх, оношилгоо эмчилгээг үзөвшөөрч байгаа эсэхийг асууна.

9. Өндөр эрсдэлтэй эмтэй харьцах- эм зүйн албанаас ижил савлагаатай, нэршил төстэй, өндөр эрсдэлтэй эмийн мэдээллийн санг эмч, сувилагч, эх баригч нар тогтмол ашиглан эрсдэлээс урьдчилан сэргийлэх дадала эзэмшсэн байна.

10. эмийн түүвэрт өндөр эрсдэлтэй эмийн жагсаалтанд орсон эмийн нэрийг BOLD хэлбэрээр ялган таньж өгөх ба түүврийг хянаж буй тасгийн эрхлэгчид өгнө.

Харахад төстэй савалгаатай болон нэршил төстэй эмийг өвчтөнд хэрэглэхийн өмнө эмийн түүвэр өвчтөний түүхэндэх эмийн нэртэй нь тулгана.

11. эрүүл мэндийн ажилтнууд халдвараас урьдчилан сэргийлэх дэглэмийг баримтлан үйлчлүүлэгчдэд олон эмэнд дасалтай нянгийн халдвар тархахаас чанд сэргийлнэ.

12. спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хэрэглэнэ. Гараа савандаж угаана.

13 эмчлүүлэгчийн өрөөнд орохын өмнө нэг удаагийн хамгаалах хувцас бээлий өмсөх ба гарахдаа тайлна.

14. эмчлүүлэгчийн биеийн шингэн, боолт, шарханд хүрэх бүх тохиолдолд нэг удаагийн бээлий өмсөнө. Эмчлүүлэгч хооронд бээлийг заавал солино.

15. нэг удаагийн халад, малгайг олон эмийн тэсвэртэй нянтай эмчлүүлэгчид том талбайгаар хүрэлцэх үед өмсөж хэрэглэнэ. амны хаалт, нүүрний хаалт, нүдний шилийг асгарсан цацагдсан биологийн шингэн цэвэрлэх, өвчтөний бие толгой угаах, өмгөн шингэнийг ариун цэврийн өрөөнд асгах зэрэгт заавал хэрэглэнэ.

16. “Code blue” эмнэлгийн бүх албан хаагчид дуудлагын хариу арга хэмжээг авахад бэлтгэгдсэн байна. Өвчтөний овог нэр, онош, байршил тусламжийн үр дүнг тусган нэгдүгээр сувилагч хөтөлнө. Батлагдсан хуваарийн дагуу идэвхжүүлэхэд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дуудлага аваагүй, хугацаандаа тусламж үйлчилгээг үзүүлээгүй бол холбогдох хууль эрх зүйн дагуу хариуцлага тооцно.

17. тасгууд тогтмол өрөөнийагааржуулалтыг сэлгэж ажиллах, өрөөний агааржуулалтыг заасан температураас хэтрүүлэхгүй байх, химийн хор болон хорт бодис ашиглаж байх үед агааржуулалт агаар сорогч ажиллуулах

18. ажлын байранд тавигдах шаардлага- Эм тариаг зориулалтын сав, шүүгээнд хаягжуулан хадгална. Ажлын байрыг хүндэтгэх шалтгаангүйгээр орхиж явахыг хориглоно.

19. Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд болон хувийг ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, гамшгийн тухай хууль, ариун цэврийн тухай хууль, төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолтонд заасан үүргээ биелүүлээгүй, Хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн эмч, ажилчдад захирлын тушаалаар сахилгын шийтгэлийг хөдөлмөрийн тухай хуулинд зааснаар ноогдуулна.

20. Ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх чвцдаа өөрийн буруугаас байгууллагад хохирол учруулсан бол хөдөлмөрийн тухай хуулинд зааснаар хохирол урчуулсан ажилтанд сахилгын захиргааны эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хязгаарлагдмал болон бүрэн хариуцлагыг хүлээлгэнэ.

ҮЙЛЧЛЭГЧИЙН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ АЮУЛГҮЙ
АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа ажил үүргийг гүйцэтгэж хэвших
2. Эрүүл мэндийн байгууллагад хийх цэвэрлэгээг тасаг, нэгжийн үйл ажиллагаа, халдварын эрсдэлээс хамааруулан 3 бүсэд хуваана. Үүнд:
 - Энгийн буюу С бүс
 - Дунд эрсдэлтэй буюу В бүс
 - Өндөр эрсдэлтэй буюу А бүс
3. Энгийн бүсэд С-захиргаа, хонгил, сургалтын болон ажилчдын амрах өрөө, агуулах зэрэг хамаарах бөгөөд цэвэрлэгээг угаалгын бодистой ус ашиглан өдөр бүр хийнэ.
4. Дунд эрсдэлтэй бүсэд В-хүлээн авах, хүлээлгийн өрөө, амбулатори, оношзүйн хэсэг, үзлэгийн өрөө, халдварт бус өвчнийтасаг, эмч, сувиалагчийн өрөө, сахиур болон ар гэрийнхний байрлах өрөө, нөхөн сэргээх эмчилгээний хэсэг, эмийн сан, гал тогоо, угаалга зэрэг хамаарах бөгөөд угаалгын болон халдваргүйтгэлийн бодис ашиглан цэвэрлэгээг өдөрт 2-оос доошгүй удаа болон бохирдсон тухай бүрд хийнэ.
5. Өндөр эрсдэлтэй бүсэд А-Мэс заслын өрөө, боолтын болон ажилбарын өрөө, дуран, төрөх, нярай, хүүхэд, эрчимт эмчилгээний тасаг, гемодиализ, яаралтай тусламжийн хэсэг, хүнд өвчтөний болон халдварт өвчтөний тасаг, эм найруулах, лаборатори, төвлөрсөн ариутгалын хэсэг, угаалгын бохир хүлээн авах хэсэг, хог хаягдал цуглуулах байр, ариун цэврийн өрөө хамаарах бөгөөд өдөрт 3- аас доошгүй удаа бохирдсон даруйд угаалга, халдваргүйтгэлийн бодистой уусмалаар цэвэрлэгээ, халваргүйтгэлийг өндөр үр дүнтэй хийнэ.
6. Цэвэрлэгээ хийхдээ дараах ерөнхий зарчмуудыг баримтална. Үүнд:
 - өдөр тутмын буюу байнгын цэвэрлэгээг тухайн тасаг нэгжийн ажил үйлчилгээнээс хамаарч хийнэ. Их цэвэрлэгээг 14 хоногт нэг удаа хийх
 - их цэвэрлэгээг бүх гадаргуу (хана, тааз, шал), хаалга, цонх шат, хаалганы бариул, шугам хоолой болон тавилга хэрэгсэл, эмчилгээ йүлчилгээнд хэрэглэж буй бүх тоног төхөөрөмжийг хамруулан хийх
 - биологийн шингэн (цус, бөөлжис, ялгадас) асгарсан тохиолдолд халдваргүйтгэлийн бодисоор цэвэрлэж халваргүйтгэх

- хэвтэн эмчлүүлэгчийн ор, шүүгээг өвчтөн эмнэлгээс гарсан даруйд заавал халдваргүйтгэж цэвэрлэх,
 - тавилга, хана, шал, тосгуура, суултуурын алчуур, хувинг өнгөөр ялган тэмдэглэж, хооронд нь дамжуулан хэрэглэхгүй байх
 - цэвэрлэгээнд хэрэглэх халдваргүйтгэлийн бодисыг зааврын дагуу бэлтгэж, хадгалж, хэрэглэх
 - эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийн нягтралыг харгалзан цэвэрлэгээ хийх хуваарийг тухайн байгууллагын дотоод журмаар зохицуулах
 - өрөө, тасалгаанд цэвэрлэгээ хийх чвцдаа үйлчлүүлэгчийгн зөвшөөрөлгүйгээр ор болон бусад эд зүйлд нь хүрэх, сууж амрах, чимээ шуугиан гаргах зэргээр тэдэнд саад болохгүй байх
 - үйлчлэгч нар цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэгээг тусгай хяналтын хуудсан дээр тэмдэглэж хананд байрлуулна.
7. Үйлчилгээний ажилчид халвартай материал, хурц үзүүр, ирмэгтэй зүйлд өртөх эрсдэлтэй тул халдвараас сэргийлэх, халдварт өртөхгүй байх журмыг мөрдлөг болгон ажиллана.
 8. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд зохих журмын дагуу жилд 2 удаа хамрагдаж, байнгын халдвар тээгчээр илэрвэл хөдөлмөр зохицуулалт хийнэ.
 9. Ажил үйлчилгээ эхлэхийн өмнө ажлын хувцас (өмд, цамц, гутал, малгай, маск, бээлий зэрэг) өмсөнө.
 10. Ажлын хувцсыг гадагш авч явах, ажлын хувцастай эмнэлэгийн гадна орчин болон нийтийн үйлчилгээний газраар явахыг хориглоно.
 11. Ажлын байранд тохирсон зөөлөн ултай, намхан өсгийтэй, урд тал нь битүү гутал өмсөх, хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэт зөв өмсөж хэрэглэх
 12. Эмнэлгийн орчны өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг 2019 оны 11 сарын 29 ний өдрийн А/537 дугаар тушаалын гар угаах халдваргүйжүүлэх заавар нэгдүгээр, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах заавар хоёрдугаар, эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар зургаадугаар хавсралтуудын хэрэгжилтийг ханган ажил үүргээ гүйцэтгэх
 13. Ажлын байранд хальтрах, бүдрэх аюулаас урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгч болон бусдадаа шал цэвэрлэгээ хийж байх үедээ “шал нойтон хальтрах аюултай” тэмдэг тэмдэглэгээг байршуулан анхааруулах, шатны орчинд

ажиллахдаа шат алгасаж гишгэх, хий гишгэхээс болгоомжлон анхаарал болгоомжтой ажиллах

14. Ариутгалын бодисуудыг өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээнд ашиглахдаа стандартын дагуу найруулж хэрэглэх
15. Өндөрт хийгдэх цэвэрлэгээний ажлыг зөөврийн зориулалтын шат буюу найдвартай байрлуулсан тавцан дээрээс гүйцэтгэх, ингэхдээ заавал 2 лаа хамтран ажиллах
16. 1,3 метрээс 5 метр хүртэлх өндөрт шал, хашлагатай талбай цэвэрлэхдээ зөөврийн шат хамгаалах бүсийг тухай бүрд нь хэрэглэж хэвших
17. Ажилдаа ирж очих үедээ замын хөдөлгөөний аюулгүй байдлаа ханган оролцох, хальтиргаа гулгаатай үед хальтрахаас болгоомжлох
18. Холбогдох албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд хийж гүйцэтгэн ажиллахпхимийн бодис асгарсан үед стандартын дагуу цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх
19. Ажилчид болон үйлчлүүлэгчтэй зөв боловсон харьцах, унахаас сэргийлэх
20. ХАБЭА-н сургалтанд хамрагдах, аюулгүй ажиллах арга барил эзэмшсэн байх

ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН АВТОМАШИНЫ ЖОЛООЧ, АЛСЫН БОЛОН
ОЙРЫН ДУУДЛАГАД ЯВАХ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН НАРТ
ӨГӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Гэнэтийн цочмог өвчин, эмгэг, осол гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх амь тэнссэн үед эмнэлгийн тусламж үйлчилгээг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх үйлчилгээг түргэн тусламжийн үйлчилгээ гэнэ.

1. Түргэн тусламжийн үйлчилгээг үйлчлүүлэгчид хамгийн ойр байгаа тусгай зөвшөөрөл бүхий түргэн тусламжийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, өмчийн бүх хэлбэрийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг үзүүлнэ.
2. Түргэн тусламжийн үйлчилгээг яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн болон тухайн тусламжийн чиглэлээр сургагдсан эрүүл мэндийн бусад ажилтнаас бүрдсэн баг холбогдох эмнэлзүйн заавар, удирдамжийг баримтлан үзүүлнэ.
3. Эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ нь болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед түргэн тусламжийн шуурхай, бэлэн байдлыг хангаж ажиллана.
4. Үйлчлүүлэгчийн эрх, аюулгүй байдлыг дээдэлнэ. Хүнлэг энэрэнгүй байна. шашин шүтлэг, үндэс угсаа, арьсны өнгө, нийгмийн байдал, гарал, үүслээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид байна. Тусламж үйлчилгээний бэлэн, шуурхай, аюулгүй байдлын зарчмыг баримтална. Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн хэм, хэмжээг чанд баримтална.
5. Түргэн тусламжийн үйлчилгээ нь 24 цагийн бэлэн байдлыг хангасан, түргэн тусламжийн дуудлага зохицуулагч (цаашид дуудлага зохицуулагч гэх), тусламж үйлчилгээг газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад үзүүлэх мэргэшсэн дуудлагын баг (цаашид дуудлагын баг гэх)-тай байна.
6. Дуудлага зохицуулагч нь дуудлага хүлээн авч, бүртгэж, мэдээлэх, багийг хуваарилах үүрэг бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн байна.
7. Дуудлагын багийг халдварын эрсдэл, цаг агаарын халуун, хүйтэн нөхцөл, химийн хорт бодис, бусад хүндрэлтэй нөхцөл байдалд ажиллах хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангасан байна.
8. Түргэн тусламжийн үйлчилгээг MNS 6717:2018 үндэсний стандартад заасан, туулах яадвар сайтай, өвчтөн тээвэрлэх тоноглол бүхий зориулалтын автомашинаар үзүүлнэ.

9. Эрүүл мэндийн байгууллага нь түргэн тусламжийн автомашины ашиглалт, засвар үйлчилгээний судалгааг жил бүр гаргаж, шаардлагатай шинэчлэлийг хийж ажиллана.
10. Эрүүл мэндийн байгууллагууд түргэн тусламжийн автомашины хэрэглээнд халдварын сэргийлэлт, хяналтын журмыг баримтлан, хяналт тавьж ажиллана.
11. Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь холбогдох журамд заасан жолооч, автомашины аюулгүй ажиллагааны хяналтын хуудсыг хөтөлж, тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж ажиллана.
12. Дуудлагын баг нь түргэн тусламжийн үйлчилгээнд гарахын өмнө болон дараа жолооч, автомашины аюулгүй ажиллагааны хяналтын хуудсыг хөтөлж хэвшүүлсэн байна.
13. Ирүүлсэн дудлага түргэн тусламж үзүүлэх багаас 25 км дотор байршилд бол ойрын дуудлага, Ирүүлсэн дуудлага 25 км-ээс алслагдсан байршилд бол холын дуудлагад бүртгэн, хүрч очих боломжит хугацааг тодорхойлж, дуудлага өгсөн иргэнд мэдэгдэн, дуудлагын баг очих хүртэл авар арга хэмжээний зөвлөгөө өгч, өгсөн зөвлөгөө, авсан арга хэмжээг дуудлагын хуудсанд тэмдэглэн холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авна.
14. Дуудлагын баг нь мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн, жолооч, стандартад заасан шаардлага хангасан дуудлага хүлээн авах утас, түргэн тусламжийн автомашин, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, байршил тогтоогч бусад холбооны хэрэгслээр бүрэн хангагдсан байна.
15. Түргэн тусламжийн автомашин нь тоноглогдсон, амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэл, холбогдох стандарт, журамд заасан багаж, тоног, төхөөрөмжөөр хангагдсан байна.
16. Шаардлага хангасан дулаан гражид автомашиныг байршуулна.
17. Жолооч нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг мөрдөн ажиллана.
18. Аливаа зөрчил гаргасан, үнэмлэхээ хууралгасан тохиолдолд байгууллагын захирал болон механикд 24 цагийн дотор мэдэгдэнэ.
19. Жолооч аюулгүйн бүсээ заавал бүсэлнэ мөн зорчигчдыг аюулгүй бүсээ зүүхийг шаардаж зүүсний дараа хөдөлгөөнд оролцоно.

20. Өөрийн эзэмшилд байгаа автомашиныг цэвэр үзэмжтэй байлгах, техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хариуцна. Автомашинд эвсрэл гэмтэл гарсан, техникийн аюулгүй байдал алдагаж үйлчилгээнд гарах шаардлага хангахгүй тохиолдолд ажилд гарахыг хориглоно.
21. Жолооч техникийн эвдрэл гэмтэл болон хэрэгцээт засвар багажийн талаар механикд мэдэгдэх эсвэл байгууллагын захиралд тухай бүр мэдэгдэж байна. автомашины нэмэлт тоног төхөөрөмжийг ариг гамтай ашиглана.
22. Жолооч нь ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа (төвийн болон алсын дуудлагад явахдаа) автомашин болоод эмч, сувилагч, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, анхаарал болгоомжтой замын хөдөлгөөнд оролцоно.
23. Товч, бүч тасарсан, цахилгаан нь эвдэрсэн элдэв зүйлээр уяж тогтоосон, унжсан зүйлс авто машины сэнс, дугуй болон ямар нэгэн зүйлтэй орооцолдож чангаагдах аюултай тул аюулгүй байдал хангаагүй ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.
24. Жолооч болон ажилчид автомашинд засвар үйлчилгээ хийхдээ өнхрөх, гулгах, хальтрах аюулаас урьдчилан сэргийлж ивүүр хийх, гар тормосыг ажиллуулсан байна. автомашины багажийг ашиглахын өмнө бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаанд үзлэг хийсэн байна. Эюдэрсэн буюу стандарт шаардлага хангахгүй нөхцөлд тухайн албыг хариуцаж буй албан тушаалтанд хэлэх, шаардлага тавих, түүгээр ажил үйлчилгээ явуулахгүй байх эрхтэй.
25. Гал гарч болзошгүй газарт гагнуур хийх, ил гал гаргах, хийн гагнуур ажиллуулах бол урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажил хариуцсан ажилтнаас зөвшөөрөл авч ажиллана. Шатахууны банк болон түүний ойр орчимд гагнуур хийх шаардлагатай бол шатахууныг юүлж яндангийн ажилласан хийгээр үлээлгэж аюулгүй ажиллагааг хангасны дараа гагнуур хийнэ.
26. Автомашины зогсоолд автомашиныг байршуулахдаа галын аюулгүй байдлыг хангасан байна.
27. Жолооч болон засварын ажилтан автомашины өргөж доогуурх эд ангид засвар үйлчилгээ хийхдээ заавал ивүүр ашиглаж автомашиныг бүрэн хөдөлгөөнгүй болгосон байна. баллонтой хүчилтөрөгчийг сумд руу тээвэрлэхийг хатуу хориглоно.
28. Ажлын болон ажлын бус цагаар архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хатуу хориглоно.

29. Алсын дуудлагаар өвчтөн хүргэх, хөдөө орон нутагт ажлаар явах эмч, сувилагч, жолооч нь урд шөнө нь жижүүртэй хоноогүй байх (шаардлагатай тохиолдолд хүний нөөц хүрэлцээгүй үед эмчилгээ эрхэлсэн орлогч даргын томилгоогоор явж болно. Ингэхдээ аюулгүй байдлаа бүрэн хангаж замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг мөрдлөг болгон хурдаа тааруулан хөдөлгөөнд оролцоно.) эрүүл мэнд, биеийн байдлын хувьд ямар нэгэн зовуурьгүй байна. Зовуурь илэрсэн тохиолдолд дараагийн хүнийг томилуулна.
30. Алсын дуудлаганд явах, өвчтөн хүргэх, хөдөө орон нутагт ажиллах эмч, сувилагч, жолооч нар нь түргэн тусламжийн дуудлагын өрөөнд өөрийн биеэр ирж томилолтоо бичүүлж, сувилагчаас аюулгүй ажиллагааны зааварчилгааг авч гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Энэ үйл ажиллагаанд жижүүрийн ахлах эмч хяналт тавьсан байна.
31. Алсын дуудлага, өвчтөн хүргэх, хөдөө орон нутагт ажлаар явах жолооч согтуугаар машин барих, хүн тээвэрлэхийг хатуу хориглон ба жижүүрийн сувилагч нь архи согтууруулах ундаа хэрэглсэн эмч, сувилагч, жолоочийг дуудлаганд явуулахгүй байх, Эмчилгээ эрхэлсэн орлогч даргад мэдээлэх үүргийг хүлээнэ.
32. Байгалийн онц аюултай үзэгдэл зарлагдсан тохиолдолд онцгой байдлын газраас зөвшөөрөл авч дуудлаганд явна.
33. Эмч, сувилагч нь шаардлагатай эм, тариа ороох боох материал, хагалгааны хэрэгслийг бэлтгэж авч явна.
34. Өвлийн улиралд алсын дуудлаганд явах, өвчтөн хүргэх, хөдөө орон нутагт томилолтоор ажиллахаар явахдаа дулаан хувцас өмсөх, даарч хөрөхөөс болгоомжилжхувийн бэлтгэлээ сайн хангасан байх, халууны улиралд уух усны нөөцтэй явна.
35. Түргэн тусламжийн автомашины цэвэрлэгээ- бээлий, угаалгын нунтаг бүхий цэвэрлэгээний бодис хийх сав, халдваргүйжүүлэх уусмал хийх сав, цэвэрлэгээ хийх алчуур, хог хаягдлын сав, хогны уут, цэвэрлэгээний материал агуулах сагс зэргийг бэлтгэсэн байна.
36. Түргэн тусламжийн машиныг 14 хоногт машины дотор, гадна тал, шал, хана, ор, сандал бусад гадаргууг маш сайн цэвэрлэн их цэвэрлэгээг жолооч хийнэ.
37. Дуудлага хооронд түргэн тусламжийн машины гадаргууг халдваргүйжүүлэн цэвэрлэх. Үүнд:
- Түргэн тусламжийн машины уонх, хаалгыг онгойлгон агаар сэлгэлт хийх

- Үйлчлүүлэгчийн хэсэгт хүрэлцэх гадаргууд халдваргүйжүүлэх уусмалаар гадаргууг арчих болон цацаж халдваргүйжүүлэлт хийнэ.

38. Цус, биологийн шингэнээр бохирлогдсон болон хавьтал, дуслын замаар дамжих халдвартай үйлчлүүлэгчийг тээвэрлэсэн үед жолооч цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийнэ. Ариутгалын ажилтан, тархвар судлаач эмчээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авна.

ХАРУУЛЫН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ АЮУЛГҮЙ
АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Ажлын цагийг баримтлах, ажлын цагт бүтээмж өндөртэй ажиллах
2. Харуулын ажлын байранд ажиллахын өмнө албаны даргаас аюулгүй ажиллагааны зааварчилгааг бичгээр авч гарын үсэг зурж баталгаажуулах, ингэхдээ тухайн өдөр хийж гүйцэтгэх ажилтай холбоотой зааварчилгааг авна.
3. Харуулууд өөрийн хариуцсан объектын галын аюулгүй байдал, сантехникийн асуудал, иргэдэд хөтөчийн үүргийг гүйцэтгэх чадамжтай байна.
4. Ажлын байранд ажил үүрэг гүйцэтгэхдээ ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг зүй зохистой бүрэн гүйцэт өмсөж ажиллана.
5. Ажлын байртай болон хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлтэй холбоотой асуудал гарвал тухай бүр албаны даргад мэдэгдэнэ.
6. Шөнийн цагаар ажил үүрэг гүйцэтгэхдээ гадны хүн хонох магадлалтай хэсгүүдийг 3-4 удаа эргэх, бусад хариуцсан хэсгүүдэд 2-3 удаа эргэх, эргэсэн тухай рапортыг албаны даргад өглөө бүр мэдэгдэж, ээлжийн харуултай ажлын байрыг хамт явж хүлээлцэж ажиллах, хүлээлцсэн тухай рапортод заавал бичиж тэмдэглэсэн байна.
7. Ажлын байранд цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцах үедээ энэхүү тушаалын нэгдүгээр хавсралт “Эмнэлгийн тоног төхөөрөмжийг ажиллуулах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г мөрдлөг болгон ажиллана.
8. Гал унтраах хэрэгсэл ажиллуулах талаар мэдлэгтэй байх, гал түймэр, осол аваар гарсан тохиолдолд объектыг байнгын хяналттай байлгаж энэ тухай албаны даргад шуурхай мэдэгдэж хариу арга хэмжээг авах
9. Хамгаалж буй объектыг орхиж явах, гадны хүн үлдээх, ажлын цагаар архи согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно. Тасгуудаас дуудсан үед дуудлагад заавал хариу өгөх.
10. Ажил үүрэг гүйцэтгэхэд эрүүл мэндийн хувьд ямар нэгэн асуудалгүй байна. өөрийн хувийн бэлтгэлийг сайтар хангасан байна.
11. Өвлийн улиралд өөрийн хариуцсан объектын гадаад орчны цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хариуцан цас бусад хог бохирдлыг цэвэрлэх ба хүн хальтрах аюулаас урьдчилан сэргийлж цас, мөсийг заавал цэвэрлэсэн байна. их хэмжээний цас орсон тохиолдолд албанаас хүн хүч нэмэгдүүлэн цасыг

цэвэрлэж байх ингэхдээ ногоон байгууламжийн хэсэгт цасыг цуглуулах хүн, автомашины хөдөлгөөнд саад урчуулахгүй байдлаар холдуулсан байна.

- 12.Цахилгаантай холбоотой гэмтлийг өөрөө дур мэдэн засварлахыг хатуу хориглоно. Заавал мэргэжлийн цахилгаанчинд мэдэгдэнэ.
13. Ажилдаа ирж очих замдаа замын хөдөлгөөнд явган, автомашинтай аль ч хэлбэрээр оролцсон замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг баримтлан зорчих, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлнэ.
14. Бусад холбогдох хууль, дүрэм, журам, зааварчилгааг ажлын байранд ажил үүрэг гүйцэтгэх үедээ мөрдлөг болгон хэрэгжилтийг ханган ажиллана.

БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Журмын зорилго

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

1. Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй нь ажил үүргээ гүйцэтгэх явцад болон түүнтэй холбоотой үүсэх осол, эрүүл мэндийг гэмтэхээс урьдчилан сэргийлэх, ажлын байрын орчноос бий болсон аюулын шалтгааныг арилгах зорилгоор Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах хэрэгслээр хангах Хөдөлмөрийн хууль бусад холбогдох баримт бичгийг судлан хэрэгилтийг ханган ажиллах цогц арга хэмжээ юм.

2. Байгууллагын хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохион байгуулахдаа Монгол улсын хууль, Засгийн газар, ЭМЧ болон бусад эрх бүхий байгууллага, тэдгээрээс гаргасан шийдвэр, эрх зүйн баримт бийг болон дүрэм, журмыг удирдлага болгоно.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд Захирал, Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер, Тасгийн эрхлэгч, Албаны дарга, Сувилахуйн арга зүйч нар хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллана.

Гурав. Нийтлэг шаардлага

1. Байгууллагын нийт албан хаагчид ажил эхлэхээс өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын давтан зааварчилгааг амаар болон бичгээр авч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа ажил үүрэгтээ орно.

2. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн бусад албан хаагчид ажлын байранд ажлын хувцсыг кодын дагуу бүрэн өмссөн байх, мэс ажилбар хийх үед зориулалтын өмд, цамц, углааш, малгай, амны хаалт, нүүрний хаалт, нүд хамгаалах хэрэгсэл болох нүдний шилийг хагалгааны хэсгийн сувилагчийн шаардлагыг биелүүлж, халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллана.

3. Тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа хэвийн, аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

4. цахилгаан тоног төхөөрөмж, уртасгагч, залгуур, разетканд хүрэхдээ чийгтэй гараар хүрэхгүй байх, мөн галын аюулгүй байдлыг ханган анхаарал болгоомжтой ажиллах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоо ажлын байрын үзлэг шалгалтыг тогтмол хийж байна.

5. Инженер техникийн албаны инженерүүд, IT инженерүүд, Аж ахуйн албаны ажилчид, жолооч нар ажлын хувцас, хүн нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэт, зөв өмсөх, аливаа ослоос урьдчилан сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах, ажил эхлэхийн өмнө ажлын байрын үзлэг шалгалтыг хийх, ажил дууссаны дараа тухайн ажлыг байрыг цэвэрлэнэ.

Дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг жилд 2 оос доошгүй удаа зохион байгуулах бөгөөд бүх тасаг, нэгжийн албан хаагчид бүгд хамрагдсан байна.

2. Ажлын байран дахь урьдчилсан болон ээлжит, ээлжит бус зааварчилгааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер өгөх, өдөр тутмын давтан зааварчилгааг тасаг, нэгж хариуцсан сувилахуйн арга зүйч нар өгөх, олон нийтийг хамарсан урлаг, спорт, бусад ажил үүргийн зааварчилгааг цахим орчноор бичгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер өгч өдөр тутмын давтан зааварчилгааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

3. Ажлын байран дахь урьдчилсан зааварчилгааг тухайн ажилтны ажлын байрын үйл ажиллагааны чиглэл, дараалал, гүйцэтгэх ажлын онцлог, хамгаалах хэрэгсэлүүдийн ашиглах заавар, аюулгүй ажиллагааны арга барил, автомашин, цахилгаан болон гар багаж, тоног төхөөрөмж, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах, журам, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчид үзүүлэх анхны тусламжийн талаар мэдлэг мэдээллүүдийг багтаасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөрийн дагуу 2 цагийн хугацаатай сургалт хэлбэрээр өгөгдөнө.

4. ээлжит бус давтан зааварчилгааг шинэ техник технологи суурилуулах, ашиглах үед, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, ээлжийн амралт болон жирэмсний амралтын хугацаа дуусаж ажил үүрэгтээ орсон тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер өгнө.

5. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг зөрчсөн албан хаагчид, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого гарсан тасаг, албадын албан хаагчдад ээлжит давтан зааварчилгааг өгнө.

АЛБАН ТАСАЛГААНД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ерөнхий шаардлага.

ХАБЭА-н тухай хуулийн 18.1.1-д “ХАБЭА-н шаардлага хангасан ажлын байранд ажиллах эрхтэй” хэмээн ажилтны эдлэх эрхийг заасан байдаг.

Албан тасалгааны хөдөлмөрийн нөхцөл ажлын байрны орчин MNS4990:2015, Эргономикийн ерөнхий шаардлага хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй, эргономикийн ерөнхий шаардлага MNS5027:2001 стандартуудыг хангасан байна.

Оффисийн ажилтны ажлын байран дээрх хэвийн нөхцлийг хангах, эрүүл мэндийг хэвээр хадгалах зорилготой хэд хэдэн стандарт хэрэгждэг.

Үүнд:

Ажлын тогтолцооны дизайн дахь эргономикийн шаардлага MNS ISO 6385:2000

Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй, эргономикийн ерөнхий шаардлага MNS 5027:2001

ААНБайгууллага, барилга байгууламжууд гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566:2005

Орон сууц, иргэний барилгад байж болох шуугианы түвшин MNS 12.1009:1985

Оффисийн ажлын байрны орчны үзүүлэлтүүдэд зам талбай, дулаан, гэрэлтүүлэг, агааржуулалт, чийгшилт, тасалгааны өнгө будаг, ширээ сандал, техник хэрэгсэл зэрэг орно.

MNS 5027:2001 стандартад:

Тоног төхөөрөмж хананаас 1м, хоорондын зай 1,5 м-ээс багагүй.

Нэг хүнд ногдох талбайн хэмжээ 6м², эзлэхүүн нь 20м³-ээс багагүй.

Нэг хүнд ногдох ажлын байрны эзэлхүүн 20м³ бол цагт нэг хүнд 30м³ агаар, 20-40м³ бол 20 м³ агаар өгөх шаардлагатай.

Цонхгүй ажлын байранд нэг цагт 60м³ агаар солилцоо хийх шаардлагатай.

Өрөөний агаарын температур гадаад температур, улирлын байдлаас хамаарч 21-26°C байна.

Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй харьцан ажилладаг хүмүүс мэдрэл сэтгэхүйн ачаалал, бие организмын үйл ажиллагаанд гарах динамик өөрчлөлт,

ажиллах чадвар зэргийг харгалзан ажил, амралтын горимыг баримтлан ажиллах шаардлагатай.

Ажил эхэлснээс хойш 2 цаг тутамд 10-15 минут, дэлгэцнээс мэдээлэл унших, хянах, засварлах зэргээр байнга харьцан ажиллах үед 1 цаг тутамд 5-10 минут засварлана.

8 цагийн ажлын ээлжтэй үед дэлгэцтэй харьцан ажиллах нийт хугацаа 4 цагаас илүүгүй байна.

4 цагийн хугацаанд дэлгэц дээр боловсруулах тэмдэгтийн тоо 30000-40000 байна.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Гадуур хувцсыг зориулалтын шүүгээ, өлгүүрт өлгөж ажлын байранд ажил хэрэгч байдлаар хувцасласан байна.
- Ажлын ширээ, сандал, хувцасны шүүгээний бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ, компьютер, хэвлэх төхөөрөмж зэрэг цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагаа, галын аюулгүй байдал зэргийг шалгана.
- Дээрх шалгалтуудыг хийх үед ямар нэгэн гэмтэл, үл тохирол илэрвэл холбогдох ажилтанд мэдэгдэж, засч арилгасны дараа ажил үүргээ эхлүүлнэ.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Ажлын байрын эмх цэгцийг хангаж, бичиг баримтуудыг шалан дээр болон хэт өндөрт тавихгүй байна. Компьютертэй ажиллахдаа өөртөө ажиллахад амар, чөлөөтэй зүй зохистой байхуйц байрлалыг сонгон ажиллах бөгөөд 2 цаг тууамд завсарлаж нүдээ амраана.
- Хөлийн улыг шалан дээр бүрэн гишгэж байхаар сандлын өндрийг тохируулна.
- Цахилгаан хэрэгсэл болон эд хогшил эвдэрч гэмтсэн үед мэргэжлийн ажилтанд хандаж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Эвдрэл гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл, эд хогшил хэрэглэхийг хориглоно.
- Өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт, чийгшил, дулааны горимыг зохих хэмжээнд тохируулан ажиллана.
- Хаягдал цаас, хог хаягдлыг зориулалтын саванд хийнэ.
- Ажлын байранд ил гал гаргах (лаа, арц, хүж асаах, тамхи татах гэх мэт)-ыг хориглоно.
- Албан тасалгаанд хэт чанга дуу чимээ гаргах, зүй бусаар харьцах, удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр шөнийн цагаар ажиллах зэргээр хөдөлмөрийн сахилга дэг журмыг зөрчихгүй байна. Албан тасалгаанд цахилгаан зуух хэрэглэх, хоол хийхийг хатуу хориглоно.

- Ажил гүйцэтгэх явцад биед ямар нэг зовиур илрэх зэргээр эрүүл мэндэд таагүй нөхцөл үүсвэл, эмч болон шууд удирдах ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.
- Байгууллагад гал түймрийн аюул, байгалийн гамшиг тохиолдох зэргээр онцгой байдал үүссэн нөхцөлд өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээнд идэвхтэй оролцоно.
- Галын анхан шатны багаж хэрэгслийг ашиглах, гал унтраах хэрэгслийн төхөөрөмжийг ажиллуулах чадвартай байна.
- Гал түймрийн аюулын үед ажлын байрнаас дүрвэн гарах маршрут нөөц хаалга, гарцыг мэддэг байх, аюул ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байна.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Албан тасалгааны бүх цахилгаан хэрэгслүүдийг цахилгааны тэжээлээс салгаж болзошгүй аюулаас сэргийлнэ.
- Албан тасалгааны агааржуулагч, салхивч, халаагуурын аюулгүй ажиллагааг шалгана. Өрөө тасалгаагаа цоожилж лацадна.
- Шатаар буухдаа шатны бариулаас барьж гишгүүрт хөлийн улыг бүрэн гишгэж шатан дээр халтирахаас сэргийлж, болгоомжтой бууна. Цахилгаан шатанд суухдаа хэвийн ажиллаж байгааг урьдчилан шалгаж, хаалга бүрэн нээгдсэний дараа сууна.
- Ажилдаа ирж очихдоо аюулгүй, баталгаажуулсан маршрутыг сонгон аюулгүй байдлаа ханган зорчино.

Уртасгагч залгууртай ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Уртасгагч залгуурыг цахилгаанаас салгахдаа кабель утаснаас нь татаж болохгүй.
- Уртасгагч кабелиар цахилгааны байнгын буюу суурин утсыг орлуулж болохгүй. (Байшингийн хана туурганд хадаж тогтоож болохгүй)
- Цахилгааны залгуурыг уртасгахын тулд зориулалтын бус кабель холбохыг хориглоно. Залгасан уртасгагч болон хэт урт уртасгагч нь хүчдэлийн хэмжээг бууруулдаг бөгөөд багаж, төхөөрөмжийг гэмтээж болох аюултайг анхаарах.
- Уян кабель болон цахилгааны утсыг шалбарах, гэмтэхээс хамгаалах, доторх утаснуудыг тусгаарладаг бүрээс нь зүсэгдсэн, урагдсан, цуурсан эсэхийг байнга шалгаж байх. Ил монтаж хийсэн цахилгааны утас нь орооцолдох,

бүдэрч унах аюултай тул цахилгааны утсыг үүдний өрөө хана, тааз, шалан дээгүүр хөндлөн татаж болохгүй.

- Мэргэжлийн болон зөвшөөрөлтэй хүн уртасгагч утсыг засах, кабелийг солино.

Ачааг гараар өргөх, зөөх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Баглаа боодолтой болон бусад ширхэгийн ачааг зөөвөрлөхдөө гараа шархлуулахгүйн тулд бүгдийг нь урьдчилан сайтар шалгаж үзэх хэрэгтэй. (төмөр баглааны үзүүр, хадаасанд гараа ураг, зүсэх эрсдэлтэйг анхаарах) Хайрцгыг буюу боодлыг хураасан газраас авахдаа хажууд нь байгаа ачаа унахгүй, тогтвортой байдалд байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Ачааг зөвхөн хураалтын дээд талаас авбал зохино. Ачааны хүнд, хөнгөнийг сайн тохируулах, хэт хүнд, овор ихтэй ачаа өргөхгүй байх
- Ачаандаа үнэлгээ хийх-Өргөж явах хооронд ачааны зарим хэсэг хөдөлж болох эсэх (бөөрөнхий зүйлс, лонх, хуйлсан зүйл гэх мэт)
- Хөлөө зөв тавих (нэг хөлөө ачааны ард, нөгөө хөлөө явах гэж байгаа зүг рүү харуулж ачааныхаа хажууд тавь)
- Ачаанд хүрэх гэж бүсэлхийгээрээ бүү тонгой. Өвдгөө нугал. (Дараа нь доошоо тонгойж ачаандаа хүр) ачааг бүсэлхийгээрээ тонгойсон үедээ бүү өргө. Ачаа өргөж байхдаа огцом хөдөлж, эргэж болохгүй
- Ачаагаа эсрэг 2 талаас нь чанга барь. Яаж өргөхөө төлөвлө. Замд тээглэх зүйлсийг холдуул, өөрөө өргөж дийлэхгүй бол бусдаас тусламж хүс. Хүнд овор хэмжээтэй ачаа барааг өргөх зөөхдөө өргөх механизм ашигла.
- Баллон шил савыг зөөвөрлөхдөө тусгай тавиур дээр тавьж зөөвөрлөх ба ийм ачааг зөөх, өндөрт гаргахдаа бие дээрээ зөөвөрлөхийг хориглоно.
- Пургидаг ачааг зөвхөн тоос үл хэвтрэх нүдний шил ба амьсгалын зам хамгаалах хэрэгсэл хэрэглэж байгаа нөхцөлд гараар ачиж буулгаж болно.
- Өдөр бүр ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг зөв өмсөж хэрэглэнэ.
- Хүний гараар өргөх ачааны дээд хэмжээ нь стандартад заасны дагуу эмэгтэй хүн 20 кг, эрэгтэй хүн 36 кг байна. Үүнээс хэтэрсэн жинтэй ачааг хамтын хүчээр болон өргөх механизмаар хийж гүйцэтгэнэ.

Галын аюулгүй байдлыг ханган ажиллах зааварчилгаа

- Техникийн засвар, үйлчилгээ хийдэг байранд галын аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөнө.
- Шатах тослох материал арчсан алчуур, даавууг ил задгай хаяхгүй, цахилгаан, ил гал, нарны шууд тусгалаас хол байлгах

- Хаалга, гал унтраах хэрэгсэл байгаа газрын орчимд хог, хаягдал овоолох, тээврийн хэрэгслийг байрлуулах, амархан гал авалцах материалыг ил саванд хадгалахыг хориглоно.
- Хэрэв зөөврийн цахилгаан гэрэлтүүлэг хэрэглэх шаардлагатай бол гэрэлтүүлэгт хамгаалалтын тор байгаа эсэх болон залгуур тусгаарлах резинэн гуурс бүрэн, бүтэн эсэхийг шалгана.
- Гал түймэр гарсан тохиолдолд гал унтраах мэргэжлийн анги буюу Онцгой байдлын газарт мэдэгдэж, гал унтраах хэрэгсэл рүү очиж авчран сургалтанд заасан аргачлалын дагуу хэрэглэнэ.
- Гал түймэр гарсан тохиолдолд өөрийн амь нас болон бусдын амь насыг аврах, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ нэн яаралтай авна.
- Цахилгаан хэрэгслийг цахилгааны эх үүсвэрээс салгах хэрэгтэй.



БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ

Хувилбарын дугаар:1

Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-10-25

Баримт бичгийн дугаар:01

Баримт бичгийг хариуцах нэгж	Нийт тасаг, нэгжүүд		
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл	Дотоод	Баримт бичгийн түвшин	3
	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан.	Ц.Лувсандамдин Б.Эрдэнэзул	ЭМТҮЧАБ Албаны дарга Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер	
Санал өгсөн	Д.Баянмөнх	Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	
Хянаж баталсан	Г.Дашжанцан	БОЭТөвийн захирал	



БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ОРНООС УНАХ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ, АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

Хувилбарын дугаар:1
Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-10-25
Баримт бичгийн дугаар:01

Баримт бичгийг хариуцах нэгж	Нийт тасаг, нэгжүүд		
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл	Дотоод	Баримт бичгийн түвшин	3
	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан.	Ц.Лувсандамдин Б.Эрдэнэзул	ЭМТҮЧАБ Албаны дарга Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер	
Санал өгсөн	Д.Болормаа	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал	
Хянаж баталсан	Г.Дашжанцан	БОЭТөвийн захирал	



БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ

Хувилбарын дугаар:1
Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-10-25
Баримт бичгийн дугаар:01

Баримт бичгийг хариуцах нэгж	Нийт тасаг, нэгжүүд		
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл	Дотоод	Баримт бичгийн түвшин	3
	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан.	Ц.Лувсандамдин Б.Эрдэнэзул	ЭМТҮЧАБ Албаны дарга Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер	
Санал өгсөн	Д.Баянмөнх	Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	
Хянаж баталсан	Г.Дашжанцан	БОЭТөвийн захирал	

